



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 20 он 11 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар .КЭГ/  
2795

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
О.ЦОГТГЭРЭЛ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Гадаад худалдааны бодлого, түүний зохицуулалтын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: 14 хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.ЦОГТГЭРЭЛЭЭС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

**Асуулга 1. Эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн бус салбарын экспортыг бодитой дэмжих, цаашлаад экспорт, импортын нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгын хүрээнд хэрэгжүүлж буй “Монгол экспорт” болон “Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын талаар:**

Засгийн газрын 2016 оны 211 дүгээр тогтоолоор баталсан “Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг 2018 оны 278 дугаар тогтоолоор шинэчлэн “Монгол экспорт” хөтөлбөр болгон баталсан.

“Монгол экспорт” хөтөлбөрийг 2018-2020, 2021-2022 гэсэн хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд хөтөлбөрийн дор дурдсан 3 үндсэн зорилтын хүрээнд нийт 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

1. Экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, хөрөнгө оруулалт, санхүү татвар болон хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх,
2. Уул уурхайн бус бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих замаар экспортыг төрөлжүүлэх, олон улсын стандартын шаардлага хангасан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг дэмжих,
3. Худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийн хүрээг тэлэх замаар экспортыг нэмэгдүүлэх.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Гадаад харилцааны яам (ГХЯ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Сангийн яам (СЯ), Гаалийн ерөнхий газар (ГЕГ) тодорхой чиг үүрэгтэйгээр оролцож байгаагаас гадна хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүрэг бүхий Экспортыг дэмжих зөвлөлийг 2019 онд Гадаад харилцааны сайдаар ахлуулан ажиллаж байна.

Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр тусгасан. Үүнд:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Нэгж	Суурь	Зорилтот	Мэдээллийн эх сурвалж	Хариуцах байгууллага
			түвшин (он)	түвшин (он)		
			2017	2022		
1.	Монгол Улсын нийт экспортод хөдөө аж ахуйн гаралтай боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь	хувь	8,1	16,2	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан	ХХААХҮЯ, ГХЯ, ГЕГ
2.	Хөнгөн, хүнс, хөдөө аж ахуйн салбарын экспортын орлого	Сая ам.доллар	610,5	915,75	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан	ХХААХҮЯ, ГХЯ, ГЕГ

3.	Дэлхийн банкны "Бизнес эрхлэх нь" тайлангийн экспортын бүрдүүлэлт хийх хугацаа	цаг	168	134	Дэлхийн банкны "Бизнес эрхлэх нь" тайлан-2018	СЯ, ГЕГ
4.	Дэлхийн банкны "Бизнес эрхлэх нь" тайлангийн экспортын бүрдүүлэлт хийх зардал	ам.доллар	191	153	Дэлхийн банкны "Бизнес эрхлэх нь" тайлан-2018	СЯ, ГЕГ
5.	Худалдааны түнш орнуудтай тарифын болон тарифын хориг саадыг бууруулах хэлэлцээр байгуулах	тоо	1	2	ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	ГХЯ

2019 оны байдлаар экспорт 6.8 тэрбум ам доллар, түүнээс уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт 823 сая ам доллар буюу нийт экспортын 10.8%-ийг эзэлж байна. Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын хэмжээ сүүлийн 5 жилд 44 хувиар өсөөд байна. Бүтцээр нь ангилбал ноос ноолуур, нэхмэл бүтээгдэхүүн, мал амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн, төмөрлөгийн бүтээгдэхүүн, хүнсний бэлэн бүтээгдэхүүн зонхилдог. 2019 онд мах махан бүтээгдэхүүний экспорт 2016 оныхтой харьцуулахад нийт хэмжээ 6.3 дахин, үнийн дүнгийн хувьд 7.5 дахин өсч, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэсэн.

"Монгол экспорт" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 1.4 тэрбум төгрөг шаардлагатайгаас 1.1 тэрбум төгрөгийг улсын төсвийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тооцон тусгасан боловч шаардлагатай төсвийг баталж өгөлгүй өнөөг хүрсэн. Гэхдээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараахь ажлуудыг хэрэгжүүлээд байна.

1. Ерөнхий сайдын захирамжаар Экспортыг дэмжих зөвлөлийг Гадаад харилцааны сайдаар ахлуулан байгуулан ажиллуулж эхэлсэн,
2. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийг 2019 онд баталсан,
3. Олон улсын худалдааны төвийн дэмжлэгтэйгээр ГХЯ 2019 онд "Монгол Улсын худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураг" баримт бичгийг боловсруулсан бөгөөд уг баримт бичгийг Экспортыг дэмжих зөвлөлд танилцуулснаас гадна үйлдвэрлэл-худалдаа-хөрөнгө оруулалтын цогц бодлогыг дэмжихэд чиглэсэн гадаад худалдааны хуулийн төслийг боловсруулах чиглэлээр ажиллаж байна,
4. Экспортод бүтээгдэхүүнээ гаргаж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан банкны зээлийн хүүгийн хөнгөлөлтийн дэмжлэг үзүүлэх, зээлийн батлан даалт өгөх зэрэг санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг бий болгох ажлыг

Жижиг, дунд үйлдвэрийн газар (ЖДҮГ)-тай хамтран Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй Экспортыг дэмжих төслийн хүрээнд эхлүүлэв,

5. Монгол Улсад олон улсын хуурай боомт байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг судалж, санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2018 оны 104 дүгээр захирамжаар байгуулан ажиллаж байна,
6. Монгол Улс 2017 онд нэгдэж орсон Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, Монгол экспорт хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд гадаад худалдаанд холбогдох шаардлагатай бүх мэдээллийг нэг цэгээс, цаг алдалгүй авах боломжийг бүрдүүлсэн “Гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан”-тай болох ажил хийх ёстой. Ийм мэдээллийн сантай байх нь худалдааны мэдээлэл ил тод байх, худалдаа эрхлэгчдийн хувьд зардал, цаг хэмнэх буюу өргөн утгаар худалдааг хөнгөвчилж буй чухал алхам юм. Олон улсын санхүүгийн корпорацийн дэмжлэгтэйгээр худалдааны мэдээллийн нэгдсэн сан байгуулах ажил 2020 оны 5 дугаар сард эхэлсэн. Тус портал сайтад оруулах бараа бүтээгдэхүүний худалдааг зохицуулахтай холбоотой бүх төрлийн мэдээллийг цуглуулах, портал сайтад байршуулах, хяналт болон баталгаажуулалт хийх үйл явцыг дэмжих зорилгоор холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг 2020 оны 6 дугаар сард Худалдааг хөнгөвчлөх Үндэсний хорооны дэргэд байгуулсан. Портал сайтыг 2020 оны 12 дугаар сараас хэрэглээнд нэвтрүүлнэ,
7. Гадаад худалдааны нэг цэгийн үйлчилгээ бий болгох ажлыг Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр ГЕГ холбогдох байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлж байна,
8. Засгийн газрын тогтоолоор жил бүрийн 12 дугаар сарын 3 дахь долоо хоногийн Бямба гарагийг Экспортлогчдын өдөр болгож тэмдэглэж байхаар тогтов,
9. Ноос ноолуур, арьс шир, мах, сүүн бүтээгдэхүүн, мөн байгалийн гаралтай бусад экспортын бүтээгдэхүүний чанарыг Европын болон олон улсын стандартад нийцүүлэх чиглэлээр Монгол Улс, Европын Холбооны хамтын ажиллагааны бүтэц бий болгох асуудлыг ажлын түвшинд хэлэлцэж байна,
10. Төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор экспортын бараа бүтээгдэхүүнд шинэ зах зээл нээх, судалгаа, маркетингийг хөгжүүлэх зорилгоор Берлин хотноо 2020 оны 11 дүгээр сард Мэдээлэл, худалдааг дэмжих төвийг нээх, мөн ӨМӨЗО-ны Хөх хотод монголын бараа бүтээгдэхүүний “Монголд үйлдвэрлэв” төвийн үйл ажиллагааг эхлүүлэхээр хувийн хэвшилтэй хамтран ажиллаж байна,
11. ОХУ болон Беларусь, Казахстан, Киргиз, Армен (184.3 сая хэрэглэгчтэй зах зээл)-ийг багтаасан гадаад худалдааны нэгдсэн бодлого, горим бүхий, гаалийн нэгдсэн зохицуулалттай Евроазийн эдийн засгийн холбоотой Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах үр ашгийг судлах хамтарсан судалгааны ажлыг 2020 оны 9 дүгээр сараас эхлүүлэв,

12. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орсон бөгөөд БНХАУ, Энэтхэг, БНСУ зэрэг 6 улстай нийт 10677 нэр төрлийн бараанд 5%-100% тарифын хөнгөлөлт эдлэх боломж бүрдэх тул хэлэлцээрийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллана,
13. Монгол Улс 2017 онд нэгдэж орсон ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, салбар дундын зохицуулалт хийх үндсэн үүргийг хэрэгжүүлэх Худалдааг хөнгөвчлөх Үндэсний хороог байгуулж, хэлэлцээрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг батлан ажиллаж байна.

**Асуулга 2. Гадаад худалдааг дэмжих, худалдааг хөнгөвчлөх чиглэлээр өнгөрсөн хугацаанд хийгдсэн ажлууд ба цаашид хийгдэхээр төлөвлөж буй ажлуудын талаар:**

Монгол Улс ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт 2017 онд нэгдэн орсон. Уг хэлэлцээр нь далайд гарцгүй, худалдааны өртөг, ялангуяа дамжин өнгөрөх тээврийн зардал өндөртэй улс, орнуудын хувьд хил, гаалийн үйлчилгээг сайжруулах, дамжин өнгөрөх барааг түргэн шуурхай нэвтрүүлэх, түүнтэй холбоотой үл ялгаварлах зарчмыг баримтлах, чөлөөтэй дамжин өнгөрөх зарчмыг дэмжих, худалдааны зардлыг бууруулахад өндөр ач холбогдолтой юм. ДХБ-ын судлаачдын тооцоолсноор хэлэлцээрийг бүрэн хэрэгжүүлснээр далайд гарцгүй хөгжиж байгаа орнууд (ДГХБО)-ын гадаад худалдааны зардал 13.2% - 15.5%-иар буурч, ДХБ-ын гишүүн орнуудын бараа экспортлох хугацаа дунджаар 2 өдрөөр, харин бараа импортлох хугацаа 1-1.5 өдрөөр тус тус багасч, экспорт, импортод зарцуулах хугацаа одоо байгаагаас 47%-иар хэмнэгдэнэ.

Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж ажиллах Худалдааг хөнгөвчлөх Үндэсний хороог 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдөр байгуулж, хэлэлцээрийг “Худалдааг хөнгөвчлөх 2018-2022 Үндэсний хөтөч зураг”, мөн “Үндэсний хорооны стратеги төлөвлөгөө 2018-2022”-г батлан ажиллаж байна.

Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, Монгол экспорт хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд гадаад худалдаанд холбогдох шаардлагатай бүх мэдээллийг нэг цэгээс, цаг алдалгүй авах боломжийг бүрдүүлсэн “Гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан” бий болгох, Гадаад худалдааны нэг цэгийн үйлчилгээ бий болгох ажлыг олон улсын байгууллагын дэмжлэгтэй хэрэгжүүлж байна.

Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээр (Армен, Азербайжан, Бангладеш, Камбож, БНХАУ, Иран, Филиппин) 2016 онд хүчин төгөлдөр болсон нь олон улсын худалдааны хэлцлийг үр ашигтай, ил тод болгох зорилгоор худалдаатай холбоотой цахим өгөгдөл болон баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрч, солилцох нөхцлийг бүрдүүлэх замаар хил дамнасан цаасгүй худалдааг дэмжих, үндэсний болон бүс нутгийн нэг цонхны үйлчилгээ болон бусад цаасгүй худалдааны системийн харилцан уялдааг хангах зорилготой. Дурдсан үнэлгээгээр ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр болон энэхүү Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээрийг хамтад нь хэрэгжүүлснээр Монгол Улсад худалдааны зардал 30% буурна гэсэн дүн гарсан.

ГХЯ хэлэлцээрт нэгдэн орсноор гарах үр ашгийн үнэлгээ хийх, хэлэлцээрийг орчуулах, холбогдох талуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр шаардлагатай бэлтгэл ажлыг хийж ирэв. “Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээр”-т нэгдэн орох үйл явцыг хурдасгах зорилгоор АНДЭЗНК-ын НБДГ-аас санаачлан гаргасан “Элсэх/Соёрхон батлах үйл явцыг хурдасгах хөтөлбөр”-т хамрагдаж холбогдох техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээг авч ажиллаж байна.

**Асуулга 3. Гадаад худалдааны бодлогын үр дүнг илэрхийлэгч үзүүлэлтүүд болох урсгал тэнцлийн алдагдал, экспортын бүтээгдэхүүний төвлөрлийн индекс болон гадаад худалдааны бодлогын хэрэгслийг тодорхойлогч худалдааны гэрээ, хэлэлцээрийн ач холбогдол, хамгаалалтын хэмжүүр зэрэг үзүүлэлтүүд сүүлийн 10 жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн талаар**

Олон улсын худалдаатай холбоотой харилцааг зохицуулж буй гол баримт бичиг нь “Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) байгуулах тухай Марракешийн хэлэлцээр” болон түүний хавсралт болох олон талт худалдааны хэлэлцээрүүд юм.

Тухайлбал, Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (GATT), Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцээр (GATS), Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлаарх хэлэлцээр (TRIPS), Хөдөө аж ахуйн асуудлаарх хэлэлцээр (Agreement on Agriculture), Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр (TBT), Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээр (TRIMS) зэрэг бараа, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон харилцааг зохицуулсан 15 хэлэлцээр, мөн маргаан шийдвэрлэх ажиллагаа (dispute settlement), худалдааны бодлогыг хянан үзэх механизм (trade policy review mechanism)-тай холбоотой 2 хэлэлцээр байна.

Улс орнууд ДХБ-ын гишүүн болсноор дээрх хэлэлцээрийг хүлээн зөвшөөрч, хэрэгжилтийг ханган ажиллах үүрэг хүлээдэг. Үүний дагуу Монгол Улсын Их Хурлаас 1996 онд “ДХБ байгуулах тухай Марракешийн хэлэлцээр”, түүний хавсралтыг соёрхон баталснаар манай улс 1997 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр тус байгууллагын гишүүн болсон. Гишүүн болсноор тус байгууллагын үйл ажиллагаа, яриа хэлэлцээнд идэвхтэй оролцож, худалдааны бодлого, зохицуулалтыг тус байгууллагын зарчим, журамд нийцүүлэн хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Харин ДХБ-ын гишүүн болсноор ДХБ-ын Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээр, Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажиллах үүрэг хүлээхгүй. Учир нь эдгээр хэлэлцээр нь хязгаарлагдмал тооны оролцогчидтой байх бөгөөд ДХБ-ын гишүүд хэлэлцээрт нэгдэн орох эрх нь нээлттэй байна. Үүний дагуу ДХБ-ын Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээрийг УИХ-аас 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдөр соёрхон баталж, хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 2.1.1, 2.1.2-т заасан бүх бүтээгдэхүүний импортод ногдуулах гаалийн албан татварыг тэглэх үүргийн дагуу холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах бэлтгэл хангаж байна.

ДХБ-ын Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах хороонд Монгол Улс ажиглагчийн статустай оролцдог.

Монгол Улс ДХБ-ын гишүүн болсноор “Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн талаар зөвлөх төв байгуулах тухай хэлэлцээр”-т нэгдэн орох эрхтэй болсон. Үүний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанаар “Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн талаар зөвлөх төв байгуулах тухай хэлэлцээр”-т Монгол Улсын нэгдэн орох тухай протоколыг хэлэлцэн баталсан.

ДХБ-ын эрх зүйн талаар зөвлөх төвийн гишүүн болсноор тус төвөөс ДХБ-ын эрх зүйн талаар үнэ төлбөргүй зөвлөгөө авах, сургалтад хамрагдах, ДХБ-ын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо хөнгөлөлттэй нөхцөлөөр эрх зүйн зөвлөгөө авах боломж бүрдсэн. Манай улсын худалдааны бодлоготой холбоотой асуудлаар худалдааны түнш зарим улс орнуудаас асуулга тавьж, ДХБ-ын зарим хороодын хуралдаанд асуудлыг хөндсөнөөр ДХБ-ын маргаан шийдвэрлэх үйл явцад манай улс татагдан орж, өөрийн хэрэгжүүлж буй худалдааны арга хэмжээг ДХБ-ын эрх зүйн тогтолцооны хүрээнд хамгаалах магадлал нэмэгдэж байна. Иймд тус төвийн гишүүн болсноор ДХБ-ын эрх зүйгээр нарийн мэргэшсэн мэргэжилтнүүд бэлтгэхийн зэрэгцээ ДХБ-ын эрх зүйн талаар зөвлөгөө өгдөг байгууллагатай хамтран ажиллах боломж нээгдэж байгаа юм.

Гадаад худалдааны бодлогын үр дүнг илэрхийлэгч үзүүлэлтүүд болох урсгал тэнцлийн алдагдлын хүснэгтийг хавсралтаас үзнэ үү.

#### **Асуулга 4. Япон Улстай байгуулсан Чөлөөт худалдааны хэлэлцээр, мөн Европын холбооны Шинэчилсэн хөнгөлөлтийн ерөнхий системийн үр дүн, үнэлгээ, цаашид анхаарах асуудлуудын талаар:**

Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр (ЭЗТХ)-ийн эдийн засгийн зорилго нь хоёр талын худалдааг нэмэгдүүлэх, японы хөрөнгө оруулалтыг татах, аж үйлдвэрийн салбарын нэмүү өртөг шингээсэн экспортыг нэмэгдүүлэх, японы өндөр техник технологийг нэвтрүүлэх, валютын орлогыг нэмэгдүүлэх, японы тарифын болон тарифын бус саад тотгорыг багасгах, худалдааг хөнгөвчлөх, гаалийн бүрдүүлэлтийг хялбаршуулахад оршино.

Манай хоёр улс Дэлхийн гаалийн байгууллагын Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн 38 бүлгийн нийт 1355 төрлийн бараа экспортолж, импортолдог. Үүнээс монголын тал Японы импортын 24 бүлгийн 1290 төрлийн барааны 96 орчим хувь, японы тал Монголын экспортын 14 бүлгийн 65 төрлийн барааны 100 хувийг импортын гаалийн тарифаас үе шаттайгаар чөлөөлөхөөр харилцан тохиролцсон. Чингэхдээ манай улс эдгээр импортын барааны гаалийн тарифын үнийн дүнгийн 50 хувийг (825 төрлийн бараа), харин Япон Улс 99,4 хувийг (60 төрлийн бараа) хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тус тус шууд чөлөөлсөн болно.

Барааны төрлөөр авч үзвэл, БТКУС-ийн ангиллаар Монголын тал 97 бүлгийн 5700 орчим төрлийн бараа, Японы тал 97 бүлгийн 9300 орчим төрлийн барааны импортын гаалийн тарифыг бууруулахаар хэлэлцээ хийсэн. Чингэхдээ манай улс эдгээр импортын барааны гаалийн тарифын 59 хувийг (3429 төрлийн бараа), харин Япон Улс 86 хувийг (8000 төрлийн бараа) хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тус тус шууд “тэг”-лэсэн.

**Хэлэлцээрийн хэрэгжилт:** Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр нь 2016 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Хоёр орны хоорондын худалдааны эргэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар байдлаар 601,0 сая ам.долларт хүрч, хэлэлцээр байгуулахаас өмнөх 2015 оныхтой харьцуулахад 2 дахин өссөн дүнтэй байна. Манай улсын Япон Улс руу чиглэсэн экспорт 2018 онд 26.5 сая ам.доллар, 2019 онд 15.5 сая ам.доллар, харин импорт 2018 онд 561.0 сая ам.доллар, 2019 онд 585 сая ам.доллар болж тус тус өссөн дүнтэй байна. ГЕГ-ын 2019 оны статистик мэдээгээр энэ нь манай улсын нийт экспортын 0.2%, импортын 9.5%-тай тэнцэж байна.

Япон Улсаас импортолж буй барааны ихэнх хувийг суудлын автомашин, уул уурхайн хүнд даацын машин механизм, түүний сэлбэг хэрэгсэл эзэлж байгаа бол манай улсаас тус улсад экспортолж буй барааны ихэнхи хувийг ноос ноолууран бүтээгдэхүүн, хивс, хонины өлөн гэдэс, муур нохойн хоол, дайвар бүтээгдэхүүн, эсгий бүтээгдэхүүн, адууны хөлдөөсөн болон хатаасан мах, монгол гэр, хөнгөн цагаан хайлш, гоо сайхны бүтээгдэхүүн, зөгийн бал зэрэг нэр төрлийн бараа тус тус эзэлж байна. Манай улс хэлэлцээрийн дагуу Япон Улсын гарал үүсэлтэй импортын бараанд 2016 оны 6 сараас энэ 2020 оны 9 дүгээр сарын 30 хүртэлх хугацаанд нийтдээ 75.1 тэрбум төгрөгийн гаалийн албан татварын хөнгөлөлт үзүүлсэн байна

Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ)-аас ЭЗТХ-ийн хүрээнд хөнгөлөлт эдлэх барааны гарал үүслийн гэрчилгээг олгодог. МҮХАҮТ-аас 2016 онд **318 ширхэг**, 2017 онд **481 ширхэг**, 2018 онд **800 ширхэг**, 2019 онд **569 ширхэг**, 2020 онд **313** гарал үүслийн гэрчилгээг олгосон байна. Үүнээс нийт 70 гаруй аж ахуйн нэгжийн 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн тогтмол экспортод гарсан байна. Тодруулбал, хөнгөн цагаанаар хийсэн эд зүйл, шар айраг, мал амьтны өлөн гэдэс, сүлжмэл свитер, джемпер, пуловер, кардиган, жилет, болон эдгээртэй төстөй сүлжмэл эдлэл, адууны хөлдөөсөн мах, тэмээний ноосон хөнжил, адууны дэл, хонины сэмлэсэн ноос эсвэл бусад мал амьтны сэмлэсэн нарийн үс, чацарганы тос, сарлагийн хөөвөр, самнасан ноолуур, ноосон оймс, гурвалжин будаа, дайвар бүтээгдэхүүн, гэрийн тэжээвэр амьтны хоол, хонины ноосон хөнжил, вольфрам, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн хамаарч байна.

Манай улсад Япон Улсаас 1990 оноос 2020 оны эхний хагас жилийн хугацаанд нийт 952.6 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ. Японы хөрөнгө оруулалттай нийт 410 аж ахуй нэгж манай улсад бүртгэлтэй байна.

**Цаашид анхаарах асуудал:** Хоёр улс хоорондын худалдаа, хөрөнгө оруулалт өсч байгаа ч нөөц бололцоогоо бүрэн ашиглахуйц хэмжээнд хүрээгүй байна.

Хэлэлцээрийн ашиглалтыг сайжруулж үндэсний экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ГХЯ-наас МҮХАҮТ-тай хамтран тус хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой аж ахуйн нэгж, компаниудад тулгарч буй хүндрэл бэрхшээл, санал, зарим нийтлэг асуудлыг айлын талд тавиад байна.



Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн Барааны худалдаа, Гарал үүсэл, хамтын ажиллагааны дэд хороог хуралдуулахаар төлөвлөж байна.

**Европын Холбооны Шинэчилсэн хөнгөлөлтийн ерөнхий системийн тухайд:** Европын Холбоо нь Монгол Улсын хувьд худалдааны гурав дахь том түнш бөгөөд 2020 оны эхний 9 сарын байдлаар Монгол Улс, Европын Холбоо хоорондын худалдааны эргэлт 526 сая ам.долларт хүрч, Монгол Улсын нийт гадаад худалдааны 6 хувийг эзэлж байна. /2019 онд 949 сая ам.доллар буюу нийт худалдааны 7 хувийг эзэлж байв/

Монгол Улс 2005 оноос хойш Европын Холбооны Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP+)-д хамрагдан 7200 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг Европын Холбооны зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр гаргах боломжтой болсон бөгөөд одоогоор 75 аж ахуйн нэгж уг хөнгөлөлтийн системд хамрагдахаар бүртгүүлсэн байна. Энэ хүрээнд 2020 оны эхний 9 сарын байдлаар манай улс Европын Холбооны 15 улсад нийт 116.1 сая ам.долларын бараа бүтээгдэхүүнийг экспортолсноос 48 аж ахуйн нэгж 29,5 сая ам.долларын хөнгөлөлтийг GSP+ хөнгөлөлтийн системийн хүрээнд эдэлсэн байна /2019 онд 50 аж ахуйн нэгж 49,4 сая ам.долларын хөнгөлөлтийг эдэлсэн/.

Мөн түүнчлэн, Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг төрөлжүүлэх, ялангуяа уул уурхайн бус бараа бүтээгдэхүүний экспортыг дэмжих чиглэлд онцгой анхаарч ажиллаж байна. Энэ хүрээнд Европын Холбооны зах зээлд Монголын уламжлалт ноос, ноолууран сүлжмэл эдлэл, хөдөө аж ахуйн гаралтай органик хүнсний бүтээгдэхүүн, арьс ширэн эдлэл, гоо сайхны бүтээгдэхүүнийг гаргах зорилгоор Европын Холбооны Төлөөлөгчийн газар, Европын Холбооны дэмжлэгтэй хэрэгжиж байгаа Монголын худалдааг дэмжих TRAM төсөл, ГХЯ, Үндэсний хөгжлийн газар, МҮХАҮТ хамтран ХБНГУ-ын Берлин хотод Мэдээлэл, худалдааг дэмжих төвийг 2020 оны 12 дугаар сард нээхээр ажиллаж байна. Тус төвөөр дамжуулан мал, амьтны гаралтай орц найрлага бүхий гоо сайхны бүтээгдэхүүн, чацарганын тос, сарлагийн хөөвөр, торомны ноосоор хийсэн эдлэл, арьс ширэн эдлэл зэрэг дөрвөн кластер бүтээгдэхүүнийг Европын хэрэглэгчдэд хүргэхээр эхний ачааг ХБНГУ-руу тусгай үүргийг нислэгээр 2020 оны 10 дугаар сард хүргүүлээд байна.

**Асуулга 5. Шинээр байгуулахаар судалж буй болон санал солилцсон Хөнгөлөлтийн ерөнхий систем, Чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийн явц байдал болон баримтлах бодлогын талаарх мэдээллийг ирүүлнэ үү.**

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.1-д “цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна”, 3.2.5.4-д “Бүс нутгийн болон олон улсын интеграцад нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан, судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.4.8-д “Улс орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулна”, 4.4.9-д “Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх, худалдааг хөнгөвчлөх замаар урт хугацаанд өрсөлдөх чадвар бүхий цөөхөн салбарт эдийн засгаа төрөлжүүлэн хөгжүүлэх, экспортын боломж, зах зээлээ тэлэх бодлого явуулна”, 4.4.16-д “Ази-Номхон далайн бүс нутаг дахь эдийн засаг, худалдааны интеграцад идэвхтэй оролцож,

эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар худалдааг нэмэгдүүлнэ” зэрэг зорилтыг дэвшүүлсэн.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас 2017 онд БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр байгуулах боломжийг судлах Хамтарсан судалгааг гүйцэтгэсэн бөгөөд БНХАУ, Евроазийн Эдийн Засгийн Холбоотой тус тус чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах Хамтарсан судалгааг эхлүүлээд байна. Мөн түүнчлэн, Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт 2020 онд нэгдэн орж, хэлэлцээрийг 2021 оноос хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.

**Бүгд Найрамдах Солонгос Улс /БНСУ/ -тай Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр байгуулах боломжийг судлах Хамтарсан судалгаа хийх ажлын даалгаврыг 2016 оны 9 дүгээр сард айлын талтай баталгаажуулсан. Хамтарсан ажлын хэсгийн уулзалтыг 2017 онд 4 удаа хийж, мөн оны эцсээр судалгааны ажлыг эцэслэсэн. Улмаар судалгааны дүнг Гадаад харилцааны сайдын зөвлөлийн хуралдаан болон Засгийн газрын хуралдаанд тус тус танилцуулсан. Хэлэлцээг эхлүүлэх нөхцлийг тохирох саналтай байгаагаа манай талаас айлын талд тавьсан ба солонгосын тал одоогийн байдлаар ЭЗТХ байгуулах яриа хэлэлцээг бусад олон улстай явуулж байгаа тул ойрын хугацаанд Монгол Улстай хэлэлцээ хийх хүн хүчний нөөц боломж дутмаг байгаа тухай мэдэгдсэн. Хэлэлцээр байгуулах асуудлыг урагшлуулах зорилгоор ГХЯ-ны ГХЭЗХАГ-ын захирал, БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамны Чөлөөт худалдааны хэлэлцээрийн бодлогын газрын дарга нар 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр цахим уулзалт хийсэн. Уулзалтаар дотоод процедурыг эхлүүлэх зорилтын хүрээнд эхний ээлжинд хамтарсан судалгааны тоо баримтыг шинэчлэх талаар тохирсон.**

**Бүгд Найрамдах Хятад Ард Улс /БНХАУ/ Монгол Улс хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийн талаар хамтарсан судалгаа хийх Монголын талын багийн бүрэлдэхүүн, удирдамжийг Гадаад харилцааны сайдын 2018 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн А/55 тоот тушаалаар батлуулсан. Хамтарсан судалгааны багийн анхдугаар уулзалтыг Улаанбаатар хотноо 2018 оны 09 дүгээр сарын 26-27-ны өдрүүднд зохион байгуулсан. Тус уулзалтаар хамтарсан судалгааны ажлын даалгаврыг тохиролцсон. Хамтарсан судалгааны багийн хоёрдугаар уулзалтыг 2019 оны 2 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд Бээжин хотноо зохион байгуулсан. Уулзалтаар хамтарсан судалгааны ерөнхий хүрээ, бүтцийг тохирсон. Монгол Улс, БНХАУ-ын хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах Хамтарсан судалгааны ажил үргэлжилж байгаа бөгөөд хоёр тал судалгааны дүнг нэгтгэх ажил хараахан дуусаагүй, ЧХХ-ийн үр нөлөөллийн талаарх талуудын байр суурь зөрүүтэй байгаа болно.**

**ЕврАзийн Эдийн Засгийн Холбоо:** Монгол Улсаас ЕврАзийн Эдийн Засгийн Холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах сонирхолтойг бүх түвшинд илэрхийлж ирсний үр дүнд 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Евроазийн эдийн засгийн комиссын зөвлөлөөс Монгол Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийг судлах хамтарсан судалгааны Ажлын хэсгийг байгуулах шийдвэр гарч, улмаар талууд хамтарсан судалгааны анхны хуралдааныг 2020 оны 10 дугаар сарын 5-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан. Хуралдаанд Евроазийн эдийн засгийн холбооны нийт гишүүн орнуудын төлөөлөгчид оролцсон ба хамтарсан ажлын хэсгийн

хоёрдугаар хуралдааныг ойрын хугацаанд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.


**Ази Номхон Далайн Худалдааны Хэлэлцээр:** Монгол Улс АНДХХ-т нэгдэж орох хүсэлтээ 2009 онд илэрхийлж, цуврал яриа хэлэлцээ хийсний дүнд нэгдэн орох нөхцлөө 2018 оны 9 дүгээр сард эцэслэж хангасан. Монгол Улсын Их Хурлын чуулганы 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар “Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийг соёрхон батлах тухай” хуулийн төслийг хэлэлцэж дэмжсэн. Энэ тухай Батламж жуух бичгийг манай тал 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Бангкок хотноо НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн Комиссын гүйцэтгэх нарийн бичгийн даргад гардуулснаар Монгол Улс хэлэлцээрийн 7 дахь гишүүн улс болоод байна. Хэлэлцээрийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.

**Хөнгөлөлтийн Ерөнхий Систем:** Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн хүрээнд олгогдож буй тарифын хөнгөлөлтүүд нь харилцан олгох зарчмыг дагадаггүй бөгөөд ихэнхдээ хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнуудын хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд олгодог зарчимтай болно.

-----oOo-----

Он	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
УРСГАЛ ДАНС	-342	-885	-4,512	-5,381	-4,792	-1,934	-948	-700	-1,155	-2,207	-2,162

### УРСГАЛ ДАНС



сая ам доллар

**МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ**

Сая ам.доллараар

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
<b>I. УРСГАЛ ДАНС</b>	<b>342</b>	<b>-885</b>	<b>-4,512</b>	<b>-5,381</b>	<b>-4,782</b>	<b>-1,934</b>	<b>-948</b>	<b>-700</b>	<b>-1,155</b>	<b>-2,207</b>	<b>-2,162</b>
Бариагүй үйлчилгээний хуудал	334	475	3,517	4,456	3,918	1,011	153	0	478	1,303	834
Кредит	2,298	3,394	4,577	4,452	4,478	6,078	5,137	5,605	6,801	7,668	8,416
Дебет	2,630	3,869	8,094	8,908	8,396	7,189	5,290	5,605	6,523	8,971	9,249
1. Бариа	-178	-172	-2,669	-3,030	-2,608	178	563	1,338	1,494	676	1,158
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	1,881	2,908	4,056	3,800	3,789	5,471	4,446	4,804	5,834	6,557	7,183
1.2 Импорт Ф.О.Б (дебит)	2,059	3,080	6,725	6,830	6,397	5,293	3,884	3,466	4,341	5,881	6,025
2. Үйлчилгээ	-154	-303	-848	-1,426	-1,310	-1,289	-715	-1,338	-1,216	-1,978	-1,992
Кредит	418	486	521	652	689	607	691	801	966	1,112	1,233
Дебет	571	789	1,369	2,077	1,999	1,896	1,406	2,139	2,182	3,090	3,224
2.1 Тээвэр	-68	-111	-293	-312	-247	-190	-106	-176	-284	-561	-594
Кредит	136	175	210	205	229	204	239	255	320	354	389
Дебет	204	285	503	517	477	394	345	431	604	915	983
2.2 Аялал	25	-21	-240	-308	-383	-258	-176	-166	-137	-415	-412
Кредит	235	244	156	177	197	215	246	316	396	445	513
Дебет	210	265	396	485	580	473	422	482	533	860	925
2.3 Бусад үйлчилгээ	-111	-171	-315	-806	-680	-841	-433	-996	-795	-1,003	-986
Кредит	46	67	154	269	263	188	206	229	251	312	330
Дебет	157	238	470	1,076	942	1,029	640	1,225	1,046	1,315	1,316
3. Анхлагч орлого	-195	-598	-1,243	-1,167	-963	-973	-970	-911	-1,613	-1,228	-1,569
Кредит	24	30	43	61	52	57	59	68	76	346	394
Дебет	220	627	1,286	1,227	1,015	1,030	1,028	980	1,689	1,573	1,963
3.1 Ажилчдын цалин	-4	-32	-116	-241	-201	-113	-42	-28	-44	185	196
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-191	-565	-1,128	-925	-762	-860	-927	-883	-1,574	-1,425	-1,792
3.3 Бусад	0	0	0	0	0	0	0	0	0	6	13
4. Хоёрдогч орлого	186	187	248	242	149	150	174	212	180	324	241
Кредит	260	309	430	507	355	333	321	305	264	448	374
Дебет	75	122	182	265	207	183	147	93	85	124	134
үүнээс: Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	60	33	29	39	38	35	26	56	20	122	82
Бусад байгууллага	126	154	219	203	111	115	148	156	159	201	159
<b>II. ХӨРӨНГИЙН ДАНС</b>	<b>160</b>	<b>152</b>	<b>130</b>	<b>142</b>	<b>141</b>	<b>136</b>	<b>116</b>	<b>91</b>	<b>78</b>	<b>92</b>	<b>161</b>
1. Үйлдвэрлэгч санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (Дг)/бууралт (Кр)	0	-1	0	0	0	0	0	0	0	0	0
Кредит	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дебет	0	1	0	0	0	0	0	0	0	0	0
2. Хөрөнгийн шилжүүлэг	160	153	130	142	141	136	116	91	78	92	161
Кредит	160	153	134	144	143	136	117	94	82	93	162
Дебет	0	0	4	2	2	1	1	3	4	2	1
<b>III. САНХҮҮГИЙН ДАНС</b>	<b>160</b>	<b>152</b>	<b>130</b>	<b>142</b>	<b>141</b>	<b>136</b>	<b>116</b>	<b>91</b>	<b>78</b>	<b>92</b>	<b>161</b>
Урсгал болон хөрөнгийн дансын тэнцэл (сэлдүүлэг/-сэлдүүлэг)	181	75	482	528	451	179	833	609	1,078	2,115	2,400
<b>III. САНХҮҮГИЙН ДАНС</b>	<b>608</b>	<b>1,669</b>	<b>-4,582</b>	<b>-6,689</b>	<b>-2,808</b>	<b>-1,504</b>	<b>-788</b>	<b>-812</b>	<b>-2,599</b>	<b>-2,091</b>	<b>-2,678</b>

Санхүүгийн дансанд өөрчлөлт оруулсан үзүүлэлт (ЗЭЭЛЭЛЭГ)												
1. Шууд хөрөнгө оруулалт												
1.1	Актив											
1.1.1	Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	54	62	-4,477	-4,208	-2,019	-231	-83	4,171	-1,446	-2,137	-2,678
1.1.2	Өрийн хэрэгсэл	0	47	61	49	38	104	10	14	49	38	85
1.2	Пассив	54	16	34	16	3	3	1	0	0	-1	42
1.2.1	Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	624	1,691	4,571	4,272	2,060	338	94	-4,156	1,494	2,174	2,443
1.2.2	Өрийн хэрэгсэл	488	1,331	1,623	982	364	-26	95	-399	828	1,000	1,231
2	Багийн хөрөнгө оруулалт	136	360	2,948	3,290	1,696	364	-1	-3,758	666	1,173	1,212
		82	-894	-73	-2,500	161	-270	-248	-487	-493	-61	-372
2.1	Актив	139	-143	-17	45	18	41	29	13	-27	47	15
2.1.1	Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	6	13	28	45	18	38	34	1	-30	54	5
2.1.2	Өрийн бичиг	132	-156	-45	0	0	4	-5	12	4	-7	9
2.2	Пассив	57	751	56	2,345	-142	311	277	500	467	107	387
2.2.1	Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	4	680	7	-14	0	-3	0	4	-10	-7	7
2.2.2	Өрийн бичиг	53	71	49	2,359	-142	315	277	496	477	114	380
	2.2.2.1 Богино хугацааг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	2.2.2.2 Урт хугацааг	53	71	49	2,359	-142	315	277	496	477	114	380
3	Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	0	0	0	0	0	-1	-1	38	17	-13	6
3.1	Актив	0	0	0	0	0	3	-1	-12	0	-12	5
3.2	Пассив	0	0	0	0	0	4	1	-50	-17	0	-1
4	Бусад хөрөнгө оруулалт	-121	855	-33	-181	-950	-1,002	-455	-4,534	-677	119	5
4.1	Актив	145	1,040	698	742	625	306	233	419	-349	-110	44
4.1.1	Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.1.2	Бэлэн мөнгө ба харилцах	161	1,041	486	689	647	227	237	327	-346	-22	38
4.1.3	Зээл	-5	-4	-6	-7	3	46	2	10	-4	-38	-12
4.1.4	Даатгал, гэтгээр болон стандарт баталгааны систем	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.1.5	Худалдааны зээл ба урьдчилгаа	-11	4	218	59	-25	34	-5	82	1	-50	18
	4.1.5.1 Богино хугацааг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	4.1.5.2 Урт хугацааг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.1.5	Бусад авлага	265	185	732	923	1,575	1,308	689	4,953	329	-229	39
4.2	Пассив	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.1	Бусад хөрөнгө	-45	9	106	348	701	471	454	123	143	-33	-52
4.2.2	Бэлэн мөнгө ба харилцах	231	114	475	532	830	751	349	4,968	222	-142	156
4.2.3	Зээл	-2	-1	-2	0	0	0	0	0	0	0	0
	4.2.3.1 Төв банк	60	-9	98	113	308	259	182	229	-264	-86	-116
	4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд	29	-51	31	-14	145	93	55	53	-110	49	3
	4.2.3.3.1 Богино хугацааг	31	43	66	127	163	166	127	176	-154	-135	-119
	4.2.3.3.2 Урт хугацааг	150	10	140	125	153	139	189	571	848	487	462
	4.2.3.2 Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	22	114	239	295	369	352	-22	4,169	-362	-543	-190
	4.2.3.4 Бусад салбар	5	-19	-35	1	-135	-78	-65	-77	-36	-142	-138
	4.2.3.4.1 Богино хугацааг	17	133	275	294	503	431	43	4,246	-326	-401	-52
	4.2.3.4.2 Урт хугацааг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.4	Даатгал, гэтгээр болон стандарт баталгааны систем	4	63	150	43	44	38	-114	-139	-42	-54	-65
4.2.5	Худалдааны зээл ба урьдчилгаа	4	63	150	43	44	38	-186	-19	-42	-54	-65
	4.2.5.1 Богино хугацааг	0	0	0	0	0	0	72	-120	0	0	0
	4.2.5.2 Урт хугацааг	76	0	0	0	0	48	0	0	6	0	0
4.2.6	Бусад авлага	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4.2.7 Зээлжих тусгай эрх /Урт хугацааг/												
Т. Аяраа болон орхигуулаа												
		128	62	182	188	84	176	223	221	62	118	224
	Төлбөрийн лавцсийн нийт дүн	556	873	18	1,639	-1,867	-471	-268	1,400	-142	453	

**V. НӨӨЦ ХӨРӨНГӨ**

1. ГВУН	713	892	14	1,639	1,867	471	268	18	1,460	142	453
2. ОУВС-гийн эзэл	157	19	-4	1,604	-1,960	-533	-271	-18	1,577	-38	0
3. Тусгай санхүүжилт	0	0	0	-35	-92	-62	-3	0	117	104	0
				0	0	0	0	0	0	0	0